



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/287

Улаанбаатар хот

Албан даалгаврыг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлыг хангаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чанд сахих, иргэдэд ээлтэй, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх, төрийн албаны стандартыг мөрдөх, ажлын цаг баримтлах, цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах талаар төрийн албан хаагч нэг бүрт онцгой анхааруулж, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг Ерөнхий газрын газар, хэлтэс, төвийн дарга нар, нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар, Нийгмийн халамжийн газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, төрийн өмчийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, харьяа байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

2. Засгийн газрын албан даалгаврын 1 дүгээр зүйлийн 1.1-1.5 дахь заалт, 3 дугаар зүйлийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг сар бүрийн 20-ны дотор ирүүлэхийг байгууллагын дарга, захирал нарт, нэгтгэж тайлагнах, хяналт тавих, авах арга хэмжээний санал танилцуулахыг Тамгын газрын дарга Ж.Энхцэцэг, Хяналт мониторингийн газрын дарга Ч.Ганболд нарт даалгасугай.

ДАРГА



Б.НЯМДАВАА